



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ



ЧУХАЛ СЭДЭВ

ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ТЭМДЭГЛЭЛ

2022 ОНЫ 12 ДУГААР САР

“ЭРҮҮГИЙН ПРОЦЕССТ ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА АВАХ ЭРХИЙГ ХАНГАХ НЬ” ТЭМДЭГЛЭЛ

АРГА ЗҮЙ

Нээлттэй Нийгэм Форум нь эрх зүйн шинэчлэлийн үйл явцыг бодлогын хэлэлцүүлэг, судалгаагаар дэмжиж ажиллахыг зорьдог билээ. Энэ хүрээнд хүний эрхэд суурилсан, шударга процесс бүхий эрүүгийн эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлэхэд хувь нэмэр оруулах зорилгоор “Эрүүгийн процесс ба Хүний эрх” цуврал хэлэлцүүлгийг эхлүүлсэн юм. Эдгээр хэлэлцүүлэг нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэд хэдэн хуулийн төслийг УИХ хэлэлцэж байгаа үетэй давхцаж буйгаараа онцлог гэж үзэж байна. Цуврал хэлэлцүүлгийн зорилго эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх шатанд тулгамдаж буй хүний эрхийн асуудлыг хөндөхөд оршиж байгаа болно. Энэ удаагийн хэлэлцүүлгийг ХЗДХЯ, ХЗТТ, МХХ, МӨХ, Оюуны Инноваци ТББ-тай хамтран зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгийн улсын өмгөөлөгч, хуулийн болон хууль сахиулах байгууллага, иргэний нийгмийн төлөөлөл 100 орчим хүн оролцов. Тус хэлэлцүүлгээр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх шатанд хууль зүйн туслалцаа авах эрхийг хангаж буй эсэхийг хэлэлцсэн бөгөөд тэмдэглэлийг нь сийрүүлэн Та бүхэнд хүргэж байгаадаа баяртай байна.

ЭРҮҮГИЙН ПРОЦЕССТ ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА АВАХ ЭРХИЙГ ХАНГАХ НЬ

ЕРӨНХИЙ ТОЙМ

Эрүүгийн эрх зүйн шинэчлэл 1993 оноос эхэлж, энэ хугацаанд хоёр удаа эрүүгийн хууль тогтоомжийг шинэчлэн найруулж баталсан бөгөөд шинэчлэлийг гүнзгийрүүлэх ажил үргэлжлэн явагдаж байна. Хэдийгээр эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлэх чиглэлээр тасралтгүй ажиллаж байгаа ч нэмэлт, өөрчлөлт оруулж буй хуулийн төсөлд хүний эрхийн тулгамдсан асуудлууд орхигдсон, зарим нэмэлт, өөрчлөлт нь хүний эрхийн зөрчил дагуулж болзошгүй хэмээх шүүмж өрнөж байгааг анхаарахгүй орхих аргагүй. Тиймээс эдгээр асуудалд анхаарал хандуулж, холбогдох бүх талын оролцоог хангасан цуврал хэлэлцүүлэг өрнүүлэн, асуудал тус бүрээр илүү тодорхой, гүнзгий хэлэлцэж, хууль тогтоогч, хэрэгжүүлэгчдэд хандсан бодлогын зөвлөмж санал болгохыг зорьсон. Тус хэлэлцүүлгээр Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээгээр хамгаалагдсан хууль зүйн туслалцаа авах эрхийн баталгаа хэр байгаа болон энэ хүрээнд хууль тогтоомж, практикт тулгамдаж буй асуудлыг хөндөж ярьсан. Хэлэлцүүлгийн үеэр “Аль болох эрт шатнаас хууль зүйн туслалцаа авах эрхийн асуудал”, “Өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн хариуцлага, түүнтэй холбоотой маргааныг хянан шийдвэрлэж буй практик, тулгамдаж буй асуудал”, “Хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааны хүндрэл бэрхшээл, тулгарч буй асуудал”, “Эрүүгийн процесс дахь өмгөөлөгчийн оролцоог үр нөлөөтэй болгох асуудал” сэдвээр илтгэлүүд сонсож хэлэлцэв. Мөн “Эрүүгийн процесст хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах асуудал” сэдвээр панел хэлэлцүүлэг өрнүүлж, холбогдох хуулийн болон хууль сахиулах байгууллагын төлөөллийг урьж оролцуулсан билээ.

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ

Нэг. Аль болох эрт шатнаас хууль зүйн туслалцаа авах эрхийн асуудал

Энэ бол аливаа этгээд гэмт хэрэгт холбогдож сэжиглэгдсэн, баривчлагдсан, саатуулагдсан буюу гэмт хэрэгт шалгагдах үеэс эхлэн хууль зүйн туслалцаа авах тухай ойлголт юм. Аль болох эрт үеэс хууль зүйн туслалцаа авах эрх (right to early access to legal aid)-ийг өмгөөлүүлэх эрх (the right to legal advice and assistance) болон улсаас үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа авах эрх (the right to legal aid that is funded by the State)-ээс тусад нь авч үзэх нь зүйтэй. Учир нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эхний үе шатанд улсаас үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа авах эрх үүссэн эсэхийг шалгахад цаг хугацаа алдах магадлалтай байдаг тул ямар нэгэн шалгуур тавилгүйгээр, төлбөрийн чадвартай эсэхээс үл хамааран хууль зүйн туслалцаа авах эрхээр хангах нь эрүүгийн процесст хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой.

Манай улсын хувьд хууль зүйн туслалцаа авах эрхийг хэргийн оролцогчийн сайн дураар хэрэгжүүлэх эрх гэж үзэх хандлага ажиглагдаж байгаагийн зэрэгцээ ЭХХШТХ-д ч мөн эрт үеэс хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах асуудлыг орхигдуулсан байна. Тус хуульд баривчилсны дараа “хууль зүйн туслалцаа авах эрхтэй болох” (ЭХХШТХ §31.6-1.2), сэжигтнээс мэдүүлэг авахдаа “өөрийгөө өмгөөлөх, өмгөөлөгч сонгон авах” (ЭХХШТХ §31.11-1.2) гэсэн эрхийг танилцуулахаар хуульчилсан нь хангалтгүй юм. Учир нь ЭХХШТХ-д заасан хууль зүйн зүйн туслалцаа авах эрхтэй холбоотой бусад боломжийг танилцуулах талаарх үүргийг холбогдох этгээдэд хүлээлгээгүй. Тиймээс өмгөөлөгчөөсөө татгалзах, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд заавал өмгөөлөгчтэй байх тохиолдлууд, төлбөрийн чадваргүй бол үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа авах, өмгөөлөгчөө өөрөө сонгож чадаагүй бол төрөөс өмгөөлөгч томилуулах, өмгөөлөгчийн үйл ажиллагаа хуулиар хамгаалагдсан байдаг зэрэг мэдээлэл өгөх шаардлагыг хуульд нарийвчлан тусгах нь зүйтэй.

ЭХХШТХ-д томилогдсон өмгөөлөгч оролцуулахаар заасан нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах хамгийн гол зохицуулалт байтал томилогдсон өмгөөлөгчийг хэрхэн, яаж оролцуулах асуудлыг нарийвчлан зохицуулаагүйн зэрэгцээ томилогдсон өмгөөлөгчөөр хэн оролцох нь ч тодорхойгүй. Үүний улмаас улсын өмгөөлөгчийг томилж ажиллуулдаг практик тогтсон нь тэдний ачааллыг нэмэгдүүлж, улмаар хууль зүйн туслалцаа үнэ төлбөргүй авах иргэний эрхийг зөрчихөд хүргэж байна.

Мөн өөрийгөө өмгөөлөх, өмгөөлөгч сонгон авах эрхийг сануулаагүйгээс үүдэх үр дагаврыг зохицуулаагүйн зэрэгцээ хууль зүйн туслалцаа авах эрхээ эдлэх хүсэлт гаргасан ч хязгаарласан, татгалзсан, хойшлуулж удаашруулсан тохиолдолд эрхээ сэргээхийг шаардах, нотлох баримтаас хасуулах зэрэг хамгаалалтыг хуульчлаагүй. Өмгөөлөгч “сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчтэй ганцаарчлан уулзах, түүнээс мэдүүлэг авахад байлцах, асуулт тавих” эрхтэй (ЭХХШТХ §5.1-2.1) гэж хуульчилсан ч өмгөөлөгчид мэдэгдэх үүргийг хуульд тусгаагүй.

Төлбөрийн чадваргүй болохыг тодорхойлох арга хэт явцуу учир төлбөрийн чадваргүйгээсээ болоод хууль зүйн туслалцаа эрт үеэс авч чадахгүй байх нь түгээмэл тохиолддог. Өөрөөр хэлбэл, төлбөрийн чадваргүй болохыг тодорхойлох журам, стандарт нь нийгмийн халамж олгох өнөөгийн тогтолцоонд суурилсан. Энэ нь гэр бүлийн орлогод суурилдаг бөгөөд үүнийг хувь хүний төлбөрийн чадамжийг тодорхойлоход ашиглах нь өрөөсгөл юм.

Хоёр. Эрүүгийн процесс дахь өмгөөлөгчийн оролцоог үр нөлөөтэй болгох асуудал

Монгол Улсын Үндсэн хуулиар хүний үндсэн эрхийг баталгаажуулсан ч эрүүгийн процесст оролцож буй хүний зарим эрхийн хэрэгжилт хангалтгүй, хэлбэр төдий хэрэгжиж байгаагийн улмаас хүний халдашгүй байх эрх, шударгаар шүүгдэх эрх зөрчигдөхөд хүрч байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны процессын шударга байдал алдагдаж, зөвхөн яллах, буруутгах чиг хандлага давамгайлах болсон. Тиймээс иргэний шударгаар шүүгдэх үндсэн эрхийг хангах нэмэлт, өөрчлөлтийг ЭХХШтХ-д оруулах шаардлага үүсжээ.

Гадаадын олон улс орон эрүүгийн процесст мэтгэлцээний хоёр тал болох өмгөөлөгч, прокурорын эрх мэдлийг өрсөлдөхүйц байлгах, харилцан хяналт, тэнцвэр бий болгох зорилтын хүрээнд томоохон дэвшил гаргаад байна. Өмгөөлөгч нь энэ харилцаанд идэвхгүй оролцогч биш, харин эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгч субъектийн нэг бөгөөд нотлох баримт цуглуулах, шалгахад оролцох эрх эдлэхийн зэрэгцээ шүүхээр хэргийг эцэслэн шийдвэрлэх хуралдаанд мэтгэлцээний нэг талыг (цагаатгах) төлөөлж оролцох, ингэхдээ шүүхийн процесст тодорхой эрхтэйгээр (асуулт асуух, нотлох баримтыг шинжлэн судлах, баримт сэлт гаргаж өгөх) өмгөөлөл явуулах статустай байх хандлагатай байгааг Монголын эрүүгийн процесст нэвтрүүлэх нь зүйтэй. Хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ авах иргэдийн хэрэгцээ шаардлага, хүлээлт өндөр болсон өнөө үед ЭХХШтХ-аар өмгөөлөгчид олгогдсон эрх, боломж иргэдийн хүлээлт, шаардлагад нийцэхгүй байна.

Эрүүгийн хосолсон процесс буюу хосолсон систем нь орчин үед шинээр хөгжиж буй загвар, хандлага бөгөөд манай улсын эрүүгийн процесст ч мөн зарим хэлбэр, зарчим нь нэвтэрч байгаа ч дутагдалтай тал цөөнгүй байна. Хүний эрхийг хамгаалахад хуульчийн ажил, мэргэжил гол үүрэгтэй тул хуульчийн ажил мэргэжлийн хараат бус, бие даасан байдлыг хангахгүйгээр хүний эрхийг хамгаалах боломжгүй. Тиймээс шударга ёсыг тогтооход хараат бус, бие даасан шүүхээс гадна хараат бус, бие даасан байдал нь баталгаатай хангагдсан өмгөөлөгч чухал үүрэгтэй. Үүний тулд хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны эрх чөлөөг дэмжих нь чухал юм.

Гурав. Хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэхэд тулгамдаж буй асуудал

Хууль зүйн туслалцааны тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 онд батлагдсан бөгөөд тус хуульд улсын өмгөөлөгчийн ажиллах нөхцөл, баталгааг хангах тодорхой зохицуулалтыг хуульчилсан. Уг хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.5-д “Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Өмгөөллийн тухай хуульд заасан гишүүний татвар, өмгөөлөгчийн хариуцлагын даатгалын хураамж, хуульчийн үргэлжилсэн сургалтын төлбөрөөс улсын өмгөөлөгчөөр ажиллах хугацаанд чөлөөлөгдөх”, тус зүйлийн 19.2-т “Энэ хуулийн 19.1.5-д заасан зардлыг төр хариуцна” хэмээн зохицуулсан. Гэвч 2023 оны төсөвт хариуцлагын даатгалын хураамж, хуульчийн үргэлжилсэн сургалтын зардлыг 50 хувь бууруулан баталж, гишүүний татварыг төсөвт огт тусгаагүй байна.

Хууль зүйн туслалцааны төв болон орон нутагт ажиллаж буй улсын өмгөөлөгч түрээсийн байранд ажиллаж буй бөгөөд зарим ажлын байр стандарт шаардлага хангахгүй (Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийн улсын өмгөөлөгч нэг өрөөнд байрладаг бөгөөд уг өрөө хүйтэн, хүн тус бүрд ажлын ширээ байхгүй, үйлчлүүлэгчтэйгээ ганцаарчлан уулзах боломжгүй), техник хангамжгүй, үйлчлүүлэгчтэй тусдаа уулзах өрөө тасалгаагүй, интернэт орчингүй нөхцөлд ажиллаж байна. Мөн орон тоо хүрэлцээгүй, улсын өмгөөлөгчдийн сургалт, сурталчилгааны зардлын төсвийг хасаж баталж буй зэргээс үүдэн иргэний чанартай хууль зүйн туслалцаа авах, хувийн нууцаа хамгаалуулах зэрэг эрхийн зөрчил гарч байна.

Түүнчлэн гэрч, хохирогч хүүхдэд, ялангуяа хүчирхийллийн хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэхэд сэтгэл зүйн нарийн мэргэшсэн эмч, хуульч ажиллах шаардлагатай байдаг тул өмгөөлөгчийг энэ чиглэлээр мэргэшүүлэх сургалтад хамруулах, мэргэжлийн сэтгэл зүйч эмч ажиллуулах боломжийг судлах нь зүйтэй.

Дөрөв. Өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн хариуцлага, түүнтэй холбоотой маргааныг хянан шийдвэрлэж буй практик, тулгамдаж буй асуудал

Өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн хороо нь өмгөөлөгч мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх явцдаа хууль тогтоомжоор буюу эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдсан харилцааны аливаа зөрчил гаргах, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зан заншлын хэм хэмжээг зөрчих, түүнчлэн мэргэжлийн нэр хүндийг унагах нөхцөл байдал бий болгох зэргийг хянан шийдвэрлэдэг. Энэ төрлийн зөрчлийг хянан шийдвэрлэх явцад дараах дөрвөн төрлийн, нийтлэг зөрчил гарч байна.

- **Өмгөөлөгчийн хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх гэрээтэй холбоотой зөрчил:** Өмгөөллийн аливаа үйл ажиллагаа үйлчлүүлэгчтэй байгуулсан хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээнд үндэслэхээр Өмгөөллийн тухай хуулиар зохицуулагдсан. Тиймээс хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээгүйгээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бусдын гуйлт, хүсэлтээр оролцох нь мэргэжлийн ёс зүйн зөрчил болно. Мөн хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээг дүгнээгүйтэй холбоотой гомдлууд нэлээд байна. Үүний зэрэгцээ өмгөөллийн хөлсийг хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээнд тусгасан агуулга, хэрэг маргааны цар хүрээтэй зохих ёсоор нийцүүлээгүй, ажиллагааны явцад гарах зардлаа бодитой тооцоогүйгээс хэт өндөр хөлс нэхэх, эсхүл үзүүлж буй үйлчилгээнийх нь чанар хүлээлтэд нь хүрээгүйтэй холбоотойгоор үйлчлүүлэгч өмгөөллийн хөлсөнд өгсөн мөнгөө буцаан нэхэмжилж, мэргэжлийн хариуцлагын хороонд гомдол гаргах явдал буурахгүй байна.
- **Товлосон цагт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бэлтгэлийг хангаж шүүх хуралдаанд оролцох өмгөөлөгчийн үүргийн тухайд:** Өмгөөлөгч шүүх хуралдаанд оролцохгүй байх, үйлчлүүлэгч хөлсөө өгөөгүй гэдгээр шалтаглан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дундаас үйлчилгээ үзүүлэхгүй орхих, бусад хэлбэрээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулах, шүүх хуралдааныг хойшлуулах, өмгөөлөгчийн мэргэжлийн нэр хүндийг үл хүндэтгэн зүй бус авирлах зэргээр Өмгөөллийн тухай хууль, Өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн дүрмээр хүлээсэн нийтлэг үүргээ биелүүлээгүй зөрчил гарч байна.
- **Үйлчлүүлэгч болон хэргийн бусад оролцогч, гуравдагч этгээдийн эрхийг зөрчих тухайд:** Өмгөөлөгчийн зүгээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үйл явц, процесс ажиллагаа, хууль хэрэглээ, шүүх, прокурор, цагдаагийн байгууллагаас гаргасан шийдвэр, дээд шатны албан тушаалтан, прокурор, давах, хяналтын шатны шүүхэд гомдол гаргах зэрэг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой асуудлаар үйлчлүүлэгчдээ тухай бүр мэдээлэл өгдөггүйн улмаас өмгөөллийн үйл ажиллагаанд итгэх үйлчлүүлэгчийн итгэл алдарч, үл ойлголцол үүсэн, улмаар гомдол гаргах үндэс суурь болж байна. Өмгөөлөгч өмгөөлөл, хууль зүйн туслалцаа үзүүлэхдээ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бусад оролцогчдод хүндэтгэлтэй хандах, зүй зохистой харилцах үүрэгтэй болохыг анхаарах шаардлагатай.
- **Өмгөөллийн хуулийн этгээдийн талаар:** Өмгөөллийн тухай хуулиар өмгөөллийн хуулийн этгээд нь улсын бүртгэлд бүртгүүлснээс хойш 14 хоногийн дотор Монголын өмгөөлөгчдийн холбооны нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх үүрэгтэй. Мөн өмгөөллийн үйл ажиллагаа явуулах хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах эрх бүхий этгээд нь өмгөөлөгч байх, өмгөөллийн эрхгүй хүнд хувьцаа эзэмшүүлэх, төлөөлүүлэхийг хориглоно гэж хуульчилсан. Тиймээс Монголын өмгөөлөгчдийн холбооны нэгдсэн бүртгэлд бүртгэгдээгүй хуулийн этгээд өмгөөллийн үйл ажиллагаа явуулах эрхгүй юм.

ХЭЛЭЛЦҮҮЛГЭЭС ГАРСАН ДҮГНЭЛТ, САНАЛ, ЗӨВЛӨМЖ

- Халдашгүй байх, нотлох баримт шалгуулах, шударгаар шүүлгэх, өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, хууль зүйн туслалцаа авах эрхийн хэрэгжилт бодит байдал дээр хангалтгүй байгаа нь Үндсэн хуулиар баталгаажуулсан үндсэн эрхийн баталгааг эрүүгийн процесс болон хуулийн практикт бодитойгоор бэхжүүлэхийг шаардаж байна.
- Эрүүгийн процессын хаалттай, мэтгэлцээний бус тогтолцооны сул талын хохирогч нь иргэд төдийгүй өмгөөлөгч болж байна. Тухайлбал, эрүүгийн процесс нь оролцож буй иргэндээ хаалттай буюу яллагдагчаар татсан тогтоолын эх хувийг иргэнд өгдөггүй, иргэн, түүний өмгөөлөгч уг тогтоолыг хуулбарлан бичиж авдаг практик тогтсон.
- Эрүүгийн процесст холимог тогтолцоо нэвтрүүлж хялбаршуулсан журам, урьдчилсан хэлэлцүүлгийг ЭХХШтХ-д оруулж ирсэн ч практикт төдий л ахиц, дэвшил гарахгүй байна. Иймд эрүүгийн хууль тогтоомжийн шинэчлэлийг гүнзгийрүүлэх шаардлагатай.

Тиймээс дараах зүйлийг зөвлөж байна. Үүнд:

- Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид хууль зүйн туслалцаа авах эрхийг нь сануулахдаа хуульд заасан боломжийг бүрэн агуулсан байх шаардлагыг хуульд тусгах;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн томилогдсон өмгөөлөгчтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох, тухайлбал, томилогдсон өмгөөлөгч оролцуулах асуудлыг ямар субъект хэрэгжүүлэх, өмгөөлөгчийг хэрхэн томилох, томилогдсон өмгөөлөгчийн төлбөрийг хэрхэх зэргийг тодорхой болгох;
- Өөрийгөө өмгөөлөх хүсэлтийг бичгээр гаргаснаас бусад тохиолдолд өмгөөлөгч сонгон авах, улсын өмгөөлөгч оролцох хүртэл томилогдсон өмгөөлөгч оролцдог байхаар зохицуулах;
- Хууль зүйн туслалцааны тухай 2022 оны хуулийг нэг мөр хэрэгжүүлэх үүднээс Хууль зүйн туслалцааны төвийн бүтэц, орон тоог нэмэгдүүлэх, улсын өмгөөлөгчийн татвар хураамж, сургалт, сурталчилгааны зардал болон улсын өмгөөлөгчийн үйл ажиллагааны баталгаа болсон томилолт, бичиг хэргийн зардал, ажиллах орчин нөхцөл болох ажлын байр, интернэт орчин, техник хангамж, үйлчлүүлэгчтэй уулзах өрөө тасалгаа зэрэг асуудлыг бүрэн хангахуйц төсөв баталж, иргэний чанартай хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах;
- Хүүхэд, хохирогч хүүхэд, гэрч хүүхэд, хүчирхийллийн хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэхэд сэтгэл зүйн нарийн мэргэшсэн эмч, хуульч ажиллах шаардлагатай тул улсын өмгөөлөгчдийг мэргэшүүлэх сургалтад хамруулах, мэргэжлийн сэтгэл зүйч эмчийн орон тоо бий болгох;
- Хууль зүйн туслалцааг гэрээний үндсэн дээр үзүүлэх, гэрээгээр тохиролцсон ажлын үр дүн, биелэлтийг гэрээний талууд харилцан зөвшилцөх замаар дүгнэн ажиллаж хэвших. Өмгөөллийн ажлын хөлсийг тогтохдоо хэрэг маргааны ээдрээ төвөгтэй байдал болон зах зээлийн тогтсон жишгийг баримталж, харилцан тохиролцож байж тогтоох.

Хэлэлцүүлгийг хөтөлж,
тэмдэглэлийг сийрүүлсэн
Б.ТӨРБОЛД, Оюуны Инноваци ТББ-
ын гүйцэтгэх захирал
Хянан тохиолдуулсан:
Б.ХИШИГСАЙХАН,
ННФ-ын Эрхзүйн хөтөлбөрийн
менежер



НЭЭЛТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

Хаяг: Монгол Улс,
Улаанбаатар хот-14240,
Сүхбаатар дүүрэг,
Жамьян гүний гудамж-5/1

Утас: 976-76113207
Факс: 976-11-324857
Веб: <http://www.forum.mn>
И-мэйл: osf@forum.mn